



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/26

Шивээговь сум

Хариуцлагатай жижүүр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. XVII жарны Үзэсгэлэн болгогч хэмээх Усан туулай жилийн Сар шинийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн харуул хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах хариуцлагатай жижүүрийг 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл томилон ажиллуулсугай.

2. Хариуцлагатай жижүүрийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар, гүйцэтгэх үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа), захирамжийн хэрэгжилтийг хангаж, хариуцлагатай жижүүрт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, удирдан зохион байгуулж, хяналт тавьж, хамтран ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, Цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА П.ГАНЧИМЭГ



47  
Сумын Засаг даргын 2023 оны  
..02-р сарын 17-ны өдрийн 1126  
дугаар захирамжийн 7-р хавсралт



### ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ


2023.02.17

№	Байгууллагын нэр	Овог нэр	Утас	Он, сар, өдөр
1.	Ерөнхий боловсролын сургууль	С.Энхцэцэг	99785089	2023.02.20
2.	3 дугаар цэцэрлэг	Б.Даваадолгор	96663805	
3.	Засаг даргын Тамгын газар	Ч.Сугармаа	99972534	2023.02.21
4.	Соёлын төв	Э.Төрмандах	99626189	
5.	Эрүүл мэндийн төв	Х.Сувданцэцэг	80040349	2023.02.22
6.	"Илчлэг Шивээ" ОНӨҮГазар	Ш.Чинболд	96056446	
7.	Шивээ Овоо хувьцаат компани	Ч.Энхжаргал	99072011	2023.02.23
8.	ИТХурал	Б.Базаррагчаа	99711038	

Жижүүрт гарах цаг: 19:00

Жижүүрээс буух цаг: 24:00

Сумын Засаг даргын 2023 оны  
02-р сарын 17-ны өдрийн 17/26  
дугаар захирамжийн 4-р хавсралт



### ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ҮҮРЭГ

1. Жижүүрийн хугацаанд утас нээлттэй байлгахаас гадна Илчлэг Шивээ ААТҮГазар, ЦШС-салбар, Эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсэгтэй холбоо барьж мэдээллийг нэгтгэн сумын Засаг даргын Тамгын газарт албан ёсоор илтгэх хуудас бичиж дараагийн эргүүлд хүлээлгэж өгнө.
2. Цаг үеийн байдлыг сумын Засаг даргын Тамгын газрын 99972534 дугаарын утсаар холбогдож мэдээлэл өгч ажиллана.
3. Жижүүрүүд байгууллагуудаар биечлэн танилцаж үүрэг зөвлөмж өгч холбогдох албан тушаалтан, удирдлагуудад цаг тухайд нь танилцуулж зохих арга хэмжээ авч ажиллана.
4. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон үед Засаг даргын Тамгын газрын даргад мэдэгдэж хуваарьт өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэнэ.
5. Засаг даргын Тамгын газрын дарга хариуцлагатай жижүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сумын Засаг даргад мэдээ өгч байна.

Шаардлагатай утасны жагсаалт:

- Засаг даргын Тамгын газар (жижүүр) - 70546809
- Эрүүл мэндийн төв – 91546103, 70546103
- 3-р сургууль - 70546355
- 3-р цэцэрлэг - 70546248
- Илчлэг Шивээ ААТҮГазар - 70546417
- Цагдаагийн хэсэг - 99595934